

**“ЭРЧИМ ХҮЧ-3 ТӨСӨЛ”-ИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ МОНГОЛ УЛС, ОЛОН УЛСЫН  
СЭРГЭЭН БОСГОЛТ, ХӨГЖЛИЙН БАНК ХООРОНДЫН ЗЭЭЛИЙН  
ХЭЛЭЛЦЭЭРИЙГ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙГ  
ХЭРЭГЖҮҮЛЭХТЭЙ ХОЛБОГДОН ГАРАХ ЗАРДЛЫН ТООЦОО**

Хууль тогтоомжийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт “Хууль тогтоомжийн төслийг баталснаар тухайн хууль тогтоомжийн үйлчлэх хүрээнд хамрагдах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын үйл ажиллагаанд үүсэх зардлын тооцоог тухай бүр гаргаж, зардал, үр өгөөжийн харьцааг энэ хуулийн 12.1.4-т заасан аргачлалын дагуу тодорхойлно.” гэж заасны дагуу Хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийн төсөл батлагдсанаар уг хуулийн үйлчлэх хүрээнд хамаарах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын үйл ажиллагаанд үүсэх зардлыг Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал” /цаашид “аргачлал” гэх/-ын дагуу тооцлоо.

Тусгагдсан зохицуулалттай уялдан зардал үүсгэх болон үүсгэж болзошгүй зүйл, заалтыг Хууль тогтоомжийн тухай хууль болон Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал”-ын дагуу судлалаа.

**ХЭЛЭЛЦЭЭР СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ ХУУЛЬ БАТЛАГДСАНААР ИРГЭНД  
ҮҮСЭХ ЗАРДЛЫН ТАЛААР**

“Эрчим хүч-3 төсөл”-ийг хэрэгжүүлэх Монгол Улс, Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банк хоорондын Зээлийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төсөлд иргэнд шууд үүрэг бий болгосон заалт агуулаагүй тул аргачлалд заасны дагуу цаашид зардал үүсгэх эсэхийг тооцоолох шаардлагагүй гэж үзлээ.

**ХЭЛЭЛЦЭЭР СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ ХУУЛЬ БАТЛАГДСАНААР ХУУЛИЙН  
ЭТГЭЭДЭД ҮҮСЭХ ЗАРДЛЫН ТАЛААР**

Төслийн нийт төсөвт өртөг “Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК-ийн боловсруулсан техник эдийн засгийн үндэслэл (ТЭЗҮ)-ээр нийт 150,792.0 сая төгрөгийн (47.8 сая долларын) санхүүжилтийн 1.6 хувийг буюу 0.8 сая долларыг Монголын Улсын төсвөөс, 98.4 хувийг буюу 47.0 сая долларыг Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банкнаас санхүүжүүлэхээр тусгасан.

“Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК-ийн санхүүгийн тайлангийн сүүлийн 3 жилийн орлогын тайланг дараах хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 1. Орлогын тайлан 2022-2024 он, төгрөгөөр

| Үзүүлэлт                     | 2022               | 2023               | 2024               |
|------------------------------|--------------------|--------------------|--------------------|
| Борлуулалтын орлого          | 471,728,921,851.27 | 524,591,569,526.84 | 528,239,341,671.79 |
| Борлуулалтын өртөг           | 471,638,864,303.63 | 531,750,572,711.92 | 533,404,568,391.15 |
| Нийт ашиг                    | 90,057,547.64      | (7,159,003,185.08) | (5,165,226,719.36) |
| Бусад орлого                 | 11,613,733,847.32  | 16,345,726,111.75  | 26,530,120,324.27  |
| Бусад үйл ажиллагааны зардал | 16,490,067,743.18  | 15,842,322,290.90  | 23,599,145,817.93  |



|                            |                    |                    |                    |
|----------------------------|--------------------|--------------------|--------------------|
| Татвар төлөхийн өмнөх ашиг | (4,786,276,348.22) | (6,655,599,364.23) | (2,234,252,213.02) |
| Орлогын татварын зардал    | 164,111.11         | 3,921,244.92       | 3,792,463.66       |
| Татварын дараах ашиг       | (4,786,440,459.33) | (6,659,520,609.15) | (2,238,044,676.68) |

“Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК-ийн санхүүгийн тайлангийн сүүлийн 3 жилийн мөнгөн гүйлгээний тайланг дараах хүснэгтэд үзүүлэв.

**Хүснэгт 2. Мөнгөн гүйлгээний тайлан 2021-2023 он, төгрөгөөр**

| Үзүүлэлт                                          | 2022               | 2023               | 2024               |
|---------------------------------------------------|--------------------|--------------------|--------------------|
| Үйл ажиллагааны мөнгөн орлого                     | 127,675,385,094.50 | 144,573,940,653.44 | 179,155,305,762.66 |
| Үйл ажиллагааны мөнгөн зарлага                    | 121,678,767,965.27 | 141,984,629,329.41 | 183,716,044,016.77 |
| Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ              | 5,996,617,129.23   | 2,589,311,324.03   | (4,560,738,254.11) |
| Хөрөнгө оруулалтын мөнгөн орлого                  | 68,146,752.90      | 85,892,798.03      | 58,303,699.91      |
| Хөрөнгө оруулалтын мөнгөн зарлага                 | 2,517,364,811.09   | 5,086,244,801.49   | 3,744,089,187.70   |
| Хөрөнгө оруулалтын цэвэр мөнгөн гүйлгээ           | (2,449,218,058.19) | (5,000,352,003.46) | (3,685,785,487.79) |
| Санхүүгийн мөнгөн орлого                          | 6,683,076.67       | 13,056,522.74      | 9,273,823,470.00   |
| Санхүүгийн мөнгөн зарлага                         | 466,322,962.31     | 274,634,963.48     | 2,601,193,797.84   |
| Санхүүгийн цэвэр мөнгөн гүйлгээ                   | (459,639,885.64)   | (261,578,440.74)   | 6,672,629,672.16   |
| Бүх цэвэр мөнгөн гүйлгээ                          | 3,087,759,185.40   | (2,672,619,120.17) | (1,573,894,069.74) |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл  | 3,704,073,190.52   | 6,791,832,375.92   | 4,119,213,255.75   |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 6,791,832,375.92   | 4,119,213,255.75   | 2,545,319,186.01   |

“Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК-ийн 2022-2024 оны орлогын болон мөнгөн гүйлгээний тайлангаас харахад “Зээлийн хэлэлцээр соёрхон батлах тухай” хуулийн төсөлд тусгасны дагуу үүсэх нэмэлт зардлыг өөрийн хөрөнгөөр санхүүжүүлэх санхүүгийн боломж бүрдээгүй байна.

Иймд Зээлийн хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийн төсөлд тусгасны дагуу нэмэлт зардлын хөрөнгө оруулалтыг улсын төсөвт тусган санхүүжүүлэхээр төлөвлөж байна.

**ХЭЛЭЛЦЭЭР СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ ХУУЛЬ БАТЛАГДСАНААР ТӨРД ҮҮСЭХ ЗАРДЛЫН ТАЛААР**

“Эрчим хүч-3 төсөл”-ийг хэрэгжүүлэх Монгол Улс, Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банк хоорондын Зээлийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төсөлд төслийн үндсэн хөрөнгө оруулалтыг урт хугацаат зээлийн хөрөнгөөр, урсгал зардлыг зээлийн хөрөнгөөр бус улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэхээр төсөл хэрэгжүүлэгч Эрчим хүчний яам, Сангийн яам, хөрөнгө оруулагч Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банктай хамтран шийдвэрлэсэн.